



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.3, 13 дугаар зүйлийн 13.2.2, 13.3.5, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны "Ой тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрөл олгох тухай" 111 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Аврах анги 105-ын түүхт 50 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан тус ангийн түүхийг баяжуулан, хамт олны идэвх, бүтээлч санаачилгыг өрнүүлж, ой тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг нийслэлийн Аврах анги 105-ын захирагч (дэд хурандаа Ш.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

2. Ойн арга хэмжээний хүрээнд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Ойн арга хэмжээний хүрээнд төлөвлөсөн ажилд шаардагдах 15,900,000 (Арван таван сая есөн зуун мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЦҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
АХ дугаар тушаалын хавсралт

1117155601
УХА0038 9077073

НИЙСЛЭЛИЙН АВРАХ АНГИ 105-ЫН 50 ЖИЛИЙН ОЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Эд хөрөнгийн нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Ном	А4, 4 өнгө, 250-300гр шохойтой цаас, бүрэлттэй (Зөөлөн хавтастай ном), 90 грамм хуудас:60	300	20,000	6,000,000
2	Сувинер (Аяга)	Диаметр 75-78мм, Өндөр 58-60мм Багтаамж:180-220гр Жин:160-170гр	300	10,000	3,000,000
3	Тэмдэглэлийн дэвтэр	А4, 2 өнгө, Сайжруулсан лидрин, 250-300 гр матт цаас, Дотор цаас:80-100 гр шаргал, цагаан цаас Бэхэлгээ: Оёо болон төмөр үдээ, спираль үдээ, унаа үдээ, наалт	300	8,000	2,400,000
4	Бал	0,5мм /тосон/	300	3,500	1,050,000
5	Ойн тэмдэг	-	500	5,500	2,750,000
6	Туг байршуулах шилэн хорго	6мкв	1	116,600	700,000
Нийт 15,900,000					

---oOo---